



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сумын хүүхдийн 5-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/162/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум  
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК -ы гэрээт аудитор:  
Б.Цэрэндэжид

Утас: 99218108

Цахим хаяг: [Tserendejid1109@gmail.com](mailto:Tserendejid1109@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 70-46-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.04 № 189  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тосонцэнгэл сумын  
Хүүхдийн тавдугаар  
Цэцэрлэгийн эрхлэгч  
Г.ЦЭРМАА-Д

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэг нь 2024 онд улсын төсвөөс 676,423.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 31,381.7 мянган төгрөгийн санхүүжилттэй, 126,832.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй ажилласан байна. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 77 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлт 91.8 хувьтай байна.

### Аудитын гол асуудал

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 22 нэр төрлийн 26,338.3 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

### Бусад асуудлын хэсэг

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэг нь 2024 онд төсвийн хөрөнгөөр 1,800.0 мянган төгрөгийн мотор худалдан авч, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 28,597.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 17,022.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусган ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

D/disk/Албан бичиг/Дүгнэлт

810502066

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА; ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

  
Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛГИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	110,407,846.00	163,139,801.00
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	80,791,363.00	126,832,223.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	80,791,363.00	126,832,223.00
3121	Төгрөг	80,791,363.00	126,832,223.00
31211	Төрийн сангийн харилцах	80,791,363.00	126,832,223.00
33	АВЛАГА	288,200.00	-
335	Бусад авлага	288,200.00	-
3351	Байгууллагаас авах авлага	288,200.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	29,328,283.00	36,307,578.00
351	Түүхий эд материал	-	2,480,000.00
35110	Тусгай зориулалттай материал	-	2,480,000.00
354	Хангамжийн материал	29,328,283.00	33,827,578.00
35410	Бичиг хэргийн материал	240,000.00	-
35420	Аж ахуйн материал	16,133,303.00	17,386,803.00
35440	Түлш шатах тослох материал	2,300,000.00	5,364,000.00
35460	Хүнсний материал	2,321,080.00	292,875.00
35470	Бусад хангамжийн материал	8,333,900.00	10,783,900.00
2	ЭРГЭЛГИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	366,081,415.88	375,329,321.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	366,081,415.88	375,329,321.00
392	Биет хөрөнгө	361,480,415.88	371,058,321.00
39201	Барилга, байгууламж	356,375,710.00	356,375,710.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(34,285,684.86)	(38,095,205.40)
39205	Машин, тоног төхөөрөмж	59,855,714.00	78,678,434.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(38,901,945.58)	(42,253,677.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,271,251.50	13,271,251.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,034,629.18)	(9,698,191.74)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,200,000.00	14,200,000.00

39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,419,999.96)
393	Биет бус хөрөнгө	4,601,000.00	4,271,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хасагдуулга	(825,000.00)	(1,155,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,776,000.00	3,776,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	476,489,261.88	538,469,122.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	7,422,200.00	9,529,600.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,422,200.00	9,529,600.00
413	Өглөг	7,422,200.00	9,529,600.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,422,200.00	8,665,600.00
4136	Бусад өглөг	-	864,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	864,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	469,067,061.88	528,939,522.00
51	Засгийн газрын хувь оролцоо	469,067,061.88	528,939,522.00
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГ Сан/ орон нутгийн сан	17,294,860.00	17,294,860.00
51101	Өмч: -Төрийн өмч	17,294,860.00	17,294,860.00
512	Хуримтлагдсан үр дүн	451,772,201.88	511,644,662.00
51210	Өмнөх үеийн үр дүн	451,772,201.88	451,772,201.88
51220	Тайлант үеийн үр дүн	-	59,872,460.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	476,489,261.88	538,469,122.00

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

ДАНС	ИЕМ_NAME	ГҮЙЦЭТГЭЛ	/Төгрөгөөр/ ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	533,883,400.00	724,827,420.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,200,000.00	17,022,720.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,200,000.00	17,022,720.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	14,200,000.00	17,022,720.00
1200045	Үгэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,200,000.00	17,022,720.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	519,683,400.00	707,804,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	500,614,900.00	676,423,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	500,614,900.00	676,423,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,068,500.00	31,381,700.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,068,500.00	31,381,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	472,986,303.88	664,954,959.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	472,986,303.88	664,954,959.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	472,311,054.05	664,883,289.93
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	314,638,165.00	480,393,598.00
210101	Цалин	220,242,159.00	305,115,066.00
210102	Нэмэгдэл цалин	83,095,168.00	165,574,282.00
210104	Урамшуулал	11,300,838.00	9,704,250.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,613,302.00	61,031,192.26
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	26,731,986.95	40,817,018.90
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,144,939.59	4,740,134.19
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,826,981.47	3,502,190.56
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	619,505.75	2,367,839.38
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	6,289,888.24	9,604,009.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,258,250.17	26,246,030.05
210301	Гэрэл цахилгааны зардал	4,748,250.17	4,901,530.05
210302	Түлш, халаалтын зардал	10,210,000.00	20,744,500.00
210303	Цэвэр, бохир усны зардал	300,000.00	600,000.00
2105	Нормативт зардал	68,423,900.00	70,272,505.00
210502	Хоол	68,423,900.00	70,272,505.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	789,500.00	1,077,750.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	789,500.00	1,077,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,587,936.88	23,862,214.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,921,107.00	11,244,749.74
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,793,200.00	3,042,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,873,629.88	9,574,814.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	675,249.83	71,669.95

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	675,249.83	71,669.95
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	675,249.83	71,669.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	60,897,096.12	59,872,460.12
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	60,897,096.12	59,872,460.12

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ДАНС	ITEM_NAME	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	519,683,400.00	707,804,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	519,683,400.00	707,804,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	500,614,900.00	676,423,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	500,614,900.00	676,423,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,068,500.00	31,381,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,068,500.00	31,381,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	450,796,174.00	659,963,840.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	450,796,174.00	659,963,840.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450,120,924.17	659,892,170.05
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	308,795,429.00	474,282,290.00
210101	Үндсэн цалин	206,249,172.00	306,558,112.00
210102	Нэмэгдэл	91,245,419.00	158,081,798.00
210104	Үр дүнгийн урамшуулал	11,300,838.00	9,642,380.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	45,488,737.00	67,407,900.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	30,519,637.00	45,837,400.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,742,400.00	5,392,600.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,993,600.00	2,696,300.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	748,900.00	2,696,300.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,484,200.00	10,785,300.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	16,393,250.17	29,310,030.05
210301	Гэрэл цахилгааны зардал	4,748,250.17	4,901,530.05
210302	Түлш, халаалтын зардал	11,345,000.00	23,808,500.00
210303	Цэвэр, бохир усны зардал	300,000.00	600,000.00
2105	Нормативт зардал	62,060,300.00	67,000,900.00
210502	Хоол, хүнс	62,060,300.00	67,000,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	473,000.00	1,077,750.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,000.00	1,077,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,910,208.00	18,813,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,094,508.00	11,790,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	2,815,700.00	7,022,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	675,249.83	71,669.95
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	675,249.83	71,669.95
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	675,249.83	71,669.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(I)-(II)	68,887,226.00	47,840,860.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	530,000.00	1,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	530,000.00	1,800,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	530,000.00	1,800,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	530,000.00	1,800,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)-(IV)-(V)	(530,000.00)	(1,800,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	68,357,226.00	46,040,860.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,434,137.00	80,791,363.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	80,791,363.00	126,832,223.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

##### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0 ДАНС	51100	51300	51210+51220	
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл				
10 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	17294860.00	0.00	451772201.88	469067061.88
11 Дахин шлэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	17294860.00	0.00	451772201.88	469067061.88
13 Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
14 Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
15 Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
16 Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	59872460.12	59872460.12
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	17294860.00	0.00	511644662.00	528939522.00

**2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан / үндсэн санхүүжилт /**

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	80,791,363.00	(80,791,363.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	757,214,300.00	653,245,520.05	103,968,779.95	86.27
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	757,214,300.00	653,245,520.05	103,968,779.95	86.27
210	Бараа, үйлчилгээний зардал	757,214,300.00	653,245,520.05	103,968,779.95	86.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	590,494,200.00	474,282,290.00	116,211,910.00	80.32
210101	Үндсэн цалин	405,727,700.00	306,558,112.00	99,169,588.00	75.56
210102	Нэмэгдэл	182,059,100.00	158,081,798.00	23,977,302.00	86.83
210104	Урамшуулал	2,707,400.00	9,642,380.00	(6,934,980.00)	356.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шийтгэл	69,555,400.00	67,407,900.00	2,147,500.00	96.91
210201	Тэтгэврийн даатгал	47,298,900.00	45,837,400.00	1,461,500.00	96.91
210202	Тэтгэмжийн даатгал	5,563,300.00	5,392,600.00	170,700.00	96.93
210203	ҮОМШӨ ний даатгал	2,782,100.00	2,696,300.00	85,800.00	96.92
210204	Ажилгүйдлийн даатгал	2,782,100.00	2,696,300.00	85,800.00	96.92
210205	Эрүүл мэндийн даатгал	11,129,000.00	10,785,300.00	343,700.00	96.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	29,310,030.05	(29,310,030.05)	-
210301	Гэрэл цахилгаан	-	4,901,530.05	(4,901,530.05)	-
210302	Түлш, халаалт	-	23,808,500.00	(23,808,500.00)	-
210303	Цэвэр, бохир ус	-	600,000.00	(600,000.00)	-
2105	Нормативт зардал	68,370,000.00	67,000,900.00	1,369,100.00	98.00
210502	Хоол, хүнс	68,370,000.00	67,000,900.00	1,369,100.00	98.00
2106	Эд хогшил худалдан авах	-	2,000,000.00	(2,000,000.00)	-
210604	Урсгал засвар	-	2,000,000.00	(2,000,000.00)	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,403,900.00	1,077,750.00	1,326,150.00	44.83
210806	Мэдээллийн технологийн зардал	2,403,900.00	1,077,750.00	1,326,150.00	44.83
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	26,390,800.00	12,166,650.00	14,224,150.00	46.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,829,400.00	5,144,000.00	13,685,400.00	27.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,561,400.00	7,022,650.00	538,750.00	92.87
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	707,804,700.00	(707,804,700.00)	-
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	676,423,000.00	(676,423,000.00)	-

131001	Улсын төсвөөс санхүүжих	-	676,423,000.00	(676,423,000.00)	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	31,381,700.00	(31,381,700.00)	-
132001	Орон нутгийн төсвөөс	-	31,381,700.00	(31,381,700.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	80,791,363.00	(80,791,363.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	126,832,223.00	(126,832,223.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00		1.00 -
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22.00	22.00		
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00		
620003	Үйлчлэх ажилтан	9.00	9.00		
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	156.00	156.00		- -

## 2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан / нэмэлт санхүүжилт /

Байхгүй

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### Тосонцэнгэл сумын Хүүхдийн 5-р цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэл:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 5-р цэцэрлэгийн зорилго: : Суралцагчийн эзэмших чадамж(танин мэдэхүй, оюун ухаан, эрүүл мэнд)-ийг хөгжүүлэхэд бүх талын оролцоо, хамтын ажиллагааг хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулах зорилгын хүрээнд нийт 10 зорилт дэвшүүлэн ажилласан.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бзорилтын хүрээнд 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

#### Тосонцэнгэл сумын Хүүхдийн 5-р цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

11. Хөдөлмөрийн тухай хууль

12. Шилэн дансны тухай хууль

**Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд орсон өөрчлөлт:** 2024 оны 03 сарын 27-ны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тотоосон, Боловсролын ерөнхий хууль 2024 оны 07-р сарын 07-нд батлагдсан. Засгийн газрын 2024 оны 08 сарын 28-ны 53 дугаар тогтоолоор "Хувьсах зардлыг хэмжээ, итгэлцүүр" шинэчлэгдэн батлагдсан, Сангийн Сайдын 2024 оны 04 сарын 01-ний А/52 тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан. Мөн Засгийн газрын 2024 оны 05 сарын 29-ний 237 дугаар тогтоолоор "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1,3 "Аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна гэсний дагуу байгууллагын дотоод хяналтын комиссыг 2024 оны 09 сарын 02-ны А/12 тушаалаар шинэчлэн 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Журмаа шинэчлэн боловсруулж улирал бүр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тайлагнаж ажилладаг. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын эрхлэгч, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 5-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 5-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаархи нийт хөрөнгө өмнөх оноос 16,622.4 мянган төгрөгөөр буюу 0.97 хувиар өссөн байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	288.2	0.00	0.00
Бараа материал	29,328.2	33,827.5	4,499.3
Үндсэн хөрөнгө	366,081.4	375,329.3	9,247.9

Нийт хөрөнгө	476,489.2	538,469.1	61,979.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	469,067.1	528,939.5	59,872.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	476,489.2	538,469.1	61,979.9

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

#### Тайланд онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 29,328.2 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 110,231.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 103,252.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 33,827.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,499.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 1,800.0 төгрөгийн худалдан авалт хийж, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 17,022.7 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж жилийн эцэст 467,951.3 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 9,574.8 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 59,872.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 623,717.4 мянган төгрөг, нийт зарлагыг 623,717.4 мянган төгрөг тооцоолон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 676,423.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 31,381.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл улсын төсвийн гүйцэтгэл 659,963.8 мянган төгрөг, зарцуулсан байна.

Жилийн эцэст гүйлгээ хаасны дараа санхүүжилт нэмж олгосон байна.

### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
Хөтөлбөр га хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
71801	Сургуулийн өмнөх боловсрол				
80233	Хүүхэд хамгаалал	950.0	950.0	-	100%
81605	Эрүүл мэндийг дэмжих	2,352.7	1,744.9	607.8	74.1%
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	68,370.0	66,839.9	1,530.1	97.7%
81816	Хүүдэд ээлтэй сургалын орчин	2,806.4	2,806.4	-	100%

81823	Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх зардал	1,863.4	-	1,863.4	100%
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	604,752.6	604,752.6	-	100%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	1,173.4	-	-	100%
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>					
80109	ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	31,381.7	31,310.0	71.7	100%
<b>НИЙТ ДҮН</b>		<b>713,650.2</b>	<b>708,403.8</b>	<b>5,246.4</b>	<b>99.3%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орон нутгийн төсвөөс 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 31,381.7 төгрөг төвлөрүүлсэнээс , төсвийн гүйцэтгэл 29,310.0 мянган төгрөг зарцуулсан байна. Гэрэл цахилгаан , түлш халаалт , цэвэр бохир ус, урсгал засварт зарцуулж 71.6 мянган төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Худалдан авалтыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан.

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын Хүүхдийн 6-р цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд анхан шатны хяналт хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 5-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 664,954.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,974.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,480.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 6-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно..

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны аудитаар түүвэрт хамргдсан. 215.4 төгрөгийн төлбөрийн акт тавигдсан.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байгаагүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 162.0 мянган төгрөгийн алдаа зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа:

Байхгүй

Шийдвэрлэсэн байдал: Байхгүй

#### 5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

#### 5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

#### 5.3 Зөвлөмж

- **Илэрсэн алдаа-1:** Хүүхдийн хоолыг нормативт зардлаас 162.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан.
- **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалт, Засгийн газрын 2019 оны 450, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллах
- **Илэрсэн алдаа -1:** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2 төрлийн 26,339.3 мянган төгрөгийн хөрөнгө элэгдээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.
- **Өгсөн зөвлөмж:** Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.


Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



АУДИТЫН ТАЙЛАНГ:

АХЛАХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Огноо: 2025-02-22

176

БОЛОВСРУУЛСАН:

"ХААН СОЁМО АУДИТ" ХХК ГЭРЭЭТ АУДИТОР

Б.ЦЭРЭНДЭЖИД

Огноо: 2025-02-22